

МОНГОЛ УЛС АЗИЙН АВТО
ЗАМЫН СҮЛЖЭЭНД НЭГДСЭН НЬ,
ОДОО БА ИРЭЭДҮЙ

2006 он. 9 сар

Илтгэгч: Лхамжавын Гомбо

- Монголын Авто Замын Инженерүүдийн Нийгэмлэгийн Гүйцэтгэх Захирал
- Дэлхийн авто замын нийгэмлэгийн Замын хучилт (ТС4.3) хорооны гишүүн
- “Бүс нутгийн авто зам хөгжүүлэх төсөл”-ийн удирдагч

Азийн авто замын сүлжээ

- НҮБ-ийн АНДЭЗНК-ийн санаачилгаар 1959 оноос хэрэгжүүлж байгаа “Азийн авто зам” төсөл нь дэлхий ертөнцийн хүн ард ойртох, аялал жуулчлал, худалдааг хөгжүүлэх хүсэл эрмэлзлийг дэмжих, улмаар өргөн эрх чөлөө, нийгмийн хөгжил, амьдралын түвшинг дээшлүүлэх, НҮБ-ын зорилгод нийцсэн чухал арга хэмжээ юм.
- 1960, 1970, 1980 онуудад Ази тивийн зарим орнуудын хувьд дотоодын авто замын сүлжээг хөгжүүлэхийн зэрэгцээ хил дамнан хийгдэх тээвэр нилээд нэмэгдсэн нь “Азийн авто зам” төслийн хэрэгжилттэй шууд холбоотой байна.
- 1990 оноос “Азийн авто зам” төслийн хэрэгжилт илүү эрчимжсэн. Энэ нь дэлхийн улс орнуудыг зааглаж байсан улс төрийн саад бэрхшээл багасаж, эдийн засгийн даяаршсан үйл ажиллагаа идэвхжсэнтэй холбоотой.

- Азийн авто замын сүлжээнд нэгдэн орох чиглэлүүдийг сонгохдоо НҮБ-ээс баримталж байгаа доорх зорилтуудыг харгалзан үздэг. Үүнд:
 - Олон улсын ачаа тээвэр болон бүс нутгийн хамтын ажиллагааг дэмжих үүднээс бүс нутгийн төвүүд, нийслэл хотуудыг холбох
 - Бүс нутаг хоорондын эдийн засгийн үйл ажиллагааг дэмжих үүднээс томоохон үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн төвүүдийг холбох,
 - Авто замын болон далайн тээвэр сүлжээг хослуулан хөгжүүлэх үүднээс гол гол далайн болон усан боомтуудыг холбох,
 - Олон улсын жуулчид, аялагчид азийн авто замаар зорчихийг дэмжих үүднээс томоохон аялал жуулчлалыг төвүүдийг холбох

Азийн авто замын стандарт

Хурдны замын зэрэглэл		Дээд зэрэглэлийн (4-өөс олон эгнээтэй)				1-р зэрэглэл (4-өөс олон эгнээтэй)				2-р зэрэглэл (2 эгнээтэй)				3-р зэрэглэл (2 эгнээтэй)			
Газарзүйн ангилал		L	R	M	S	L	R	M	S	L	R	M	S	L	R	M	S
Тооцоот хурд (км/ц)		120	100	80	60	100	80	50		80	60	50	40	60	50	40	30
Өргөн (м)	Зурвас газар	(50)				(40)				(40)				(30)			
	Эгнээ	3,50				3,50				3,50				3,00 (2,25)			
	Хөвөө	3,00		2,50		3,00		2,50		2,50		2,00		1,5 (2,0)		0,75 (1,5)	
Тусгаарлах зурвас		4,00		3,00		3,00		2,50		N/A		N/A		N/A		N/A	
Хэвтээ муруйн хамгийн бага радиус (м)		520	350	210	115	350	210	80		210	115	80	50	115	80	50	30
Хучилтийн налуу (%)		2				2				2				2-5			
Хөвөөний налуу (%)		3-6				3-6				3-6				3-6			
Хучилтын төрөл		Асфальт / цемент бетон				Асфальт / цемент бетон				Асфальт / цемент бетон				Давхар гадаргуун боловсруулалт			
Хамгийн их эргэц (%)		10				10				10				10			
Хамгийн их босоо хэвгий (%)		4	5	6	7	4	5	6	7	4	5	6	7	4	5	6	7
Даац		HS20-44				HS20-44				HS20-44				HS20-44			

Монгол улс Азийн авто замын сүлжээнд нэгдэх шаардлага

- Монгол улс нь ОХУ, БНХАУ-ын хооронд орших, 1,5 сая км² өргөн уудам нутаг дэвсгэртэй, далайд гарцгүй орон. Улс орны ирээдүйн хөгжилд олон улсын хамтын ажиллагаа, үр ашигтай тээврийн сүлжээг нэг улс, бүс нутаг, тив болон тив хооронд зохистой хөгжүүлэх асуудал чухлаар тавигдах боллоо.
- Хуурай газраар хүрээлэгдсэн орныхоо хувьд Монгол улс хөрш зэргэлдээ болон бусад орнуудтай авто замын тээврээр найдвартай холбогдох, цаашид олон улсын дамжин өнгөрөх тээврийн үйл ажиллагааг идэвхтэй дэмжих шаардлагатай юм.
- “Азийн авто зам” төслийг Монгол улсын засгийн газраас байнга дэмжиж АНДЭЗНК-ийн хуурай замын тээврийн талаар хэрэгжүүлж байгаа арга хэмжээнд идэвхтэй оролцож ирсэн.
- 1991-2004 онд Азийн авто замын сүлжээг тогтоох, замын нэгдсэн стандарт боловсруулах, засгийн газар хоорондын гэрээний төсөл хэлэлцэх үйл ажиллагаанд 10 гаруй удаа оролцож, өөрийн оронд ААЗ-ын бүс нутгийн экспертүүдийн уулзалт зөвлөлгөөг 2 удаа зохион байгуулж байв.

2004 онд Засгийн газар хоорондын гэрээгээр Монгол улс Азийн авто замын сүлжээний дараах чиглэлүүдэд холбогдохоор тогтсон. Үүнд:

АН-3 чиглэл. БНХАУ-ын Тяньжинь дэх Тангу далайн боомт-Бээжин-Улаанбаатар-ОХУ-ын Улаан-Үд хүртлэх автозам. Монгол улс дахь хэсэг нь ОХУ-ын хил – Алтанбулаг – Дархан – Улаанбаатар – Сайншанд – Замын Үүд – БНХАУ-ын хил хүртэл 1041км үргэлжилэх бөгөөд Монгол улсын босоо тэнхлэгийн гол зам юм.

АН-4 чиглэл. ОХУ-ын Новосибирскээс Монгол улсын Улаанбайшинт-Өлгий-Ховд-Ярантайгаар дамжин БНХАУ-ын Үрүмчи хүрэхээр төлөвлөж байгаа. Монгол улс дахь хэсэг нь 725км.

АН-32. Ховд-Улиастай-Цэцэрлэг-Хархорин-Лүн-Улаанбаатар-Өндөрхаан-Чойбалсан-Сүмбэр /Дорнод/ чиглэлийн 2520км үргэлжлэх энэ зам нь хэвтээ тэнхлэгийн гол зам юм.

Монгол улс нийт **4286 км** замаар Азийн авто замын сүлжээнд холбогдохоор тогтоогдсон юм.

АН-3 чиглэлийн зам

- Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр дараах төслүүд хэрэгжиж АН-3 чиглэлийн замын **586**км буюу **56,3%** нь хатуу хучилттай болоод байна.

Үүнд:

- ОХУ-ын хил - Алтанбулаг-Дархан-Улаанбаатар чиглэлийн 312 км авто замын засвар шинэчлэлтийг Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Авто зам хөгжүүлэх 1-р төсөл”-ийн хүрээнд 1997-2000 онд хийж гүйцэтгэсэн.
- Налайх – Чойр чиглэлийн 200км авто замыг шинээр барих “Авто зам хөгжүүлэх 2-р төсөл” 2002-2005онд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн.

“Бүс нутгийн авто зам хөгжүүлэх төсөл”-ийн тухай

- Азийн авто замын сүлжээний АН-3 чиглэлийн Монгол улс дахь хэсэг болох Чойр - Замын Үүд чиглэлийн **432 км** хатуу хучилттай авто замыг барих “Бүс нутгийн авто зам хөгжүүлэх төсөл”-ийг Азийн хөгжлийн банк, Солонгосын Эдийн засаг хамтын ажиллагааны сангийн зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэхнэ.

Төслийн зорилго

- Монгол ОХУ-ын хооронд болон Монгол БНХАУ-ын хооронд ачаа, зорчигч тээвэрлэх боломжийг нэмэгдүүлснээр Монгол улсын худалдаа аж үйлдвэр, аялал жуулчлалын үйл ажиллагааг өргөтгөх,
- Монгол улсаар дамжин өнгөрөх ОХУ, БНХАУ хоорондын транзит тээврийн үр ашигтай сүлжээг бүрдүүлж эдгээр улсуудын бүс нутагт үзүүлэх эдийн засгийн үр өгөөжийг хүртэх зэрэг болно.
- Хил хоорондын худалдааг өргөжүүлж, ингэснээр эдийн засгийн өсөлтийг дэмжих
- Говьсүмбэр, Дорноговь аймгуудын эдийн засаг-нийгмийн хөгжлийг хурдсагаж, ядуурлыг бууруулах
- Тээврийн хэрэгслүүд олон салаа зам гарган зорчих явдлыг эцэслэн бэлчээрийн нутгийг сүйдэхээс хамгаалах, ингэснээр байгаль орчинд эерэг нөлөө үзүүлэх

Ò°ñëèéí á¿ðýëäýõ¿¿í õýñýã

- ×íéõ-Ñàéíøàíä-Çàìúí ¯¿ä ÷èãëýëä 432 èì àñôàëüò áåòíí õó÷èëòòàé àâòí çàì áàðèõ
- Íííáíë-Õÿòàäúí õèëýýð °íã°ð°õ àâòíìàøèíú õ°ä°ëã°íèéã ñààãã¿é áíëãíõ Õèë ààííàñàí àâòí òýýâðèéã õÿëáàðøóóëàõ ò°ë°âë°ã°ã õýðýãæ¿¿ëýõ
- Çàìúí õ°ä°ëã°íèé àðóëã¿é áàéäëúã ñàéæðóóëàõ ò°ñ°ë:
¿íä:
 - Óëààíáààòàð-Àëòàíáóëàãèéí çàìä õ°ä°ëã°íèé àðóëã¿é áàéäëúã õàíãàõ òýìäýã òýìäýãëýãýýã áàéðëóóëàõ,
 - Ò°ñëèéí çàìúí çóðãã ò°ñ°ëä õ°ä°ëã°íèé àðóëã¿é áàéäèë õýðõýí òóñãàãñàíúã àóäèò õèéõ,
 - Çàìúí õ°ä°ëã°íèé àðóëã¿é áàéäëúí òàèààð íèéòýä òàíèóëàõ,
 - Ýðã¿¿ëèéí ìàøèí, õóðã õýìæèã÷, áíãèíí äíëãèííú ñòàíõ õóãàëãàí àâàõ,
 - çàì õ°ä°ëã°íèé àðóëã¿é áàéäëúã ñàéæðóóëàõ çàìúí òàããààãèéí àæèëòàíóóãã ñóðãàèò çíõèíí áàéãóóëàõ

Ò°ñëèéí áçđýëäýõççí õýñýã

- Îđíí íóòãèéã õ°ãæççëýõ õ°ò°ëá°đççäèéã õýđýãæççëýõ, ççíã:
 - ò°ñ°ë õýđýãæèõ ãàçàđò íèéò 37 êì óđòòàé îđíí íóòãèéí 4 çàìûã ò°ñëèéí ãîë çàìòàé õîëáíõ,
 - ò°ñëèéí ãîë çàì áîëíí Ýđäýíý ñòì đóó ñàëñàí îđíí íóòãèéí çàìûí îãòîëõîë äýýđ çàìûí çéë÷èëãýýíèé õîãõîëáíđ áàéãóóëàõ:
 - çàì áàđèëãûí àæèë áîëíí çàìûí çàñâàđ àđ÷èàèòûí àæëûã ãçéöýòãýõ òàëààđ îđíí íóòãèéí èđãýãýã ñóđãàèò çîëèíí áàéãóóëàõ:
 - îđíí íóòãèéí àđä èđãýäèéí îđîëõîã äýìæèõ
- Õîëä-óđä ÷èãëýëéí çàìûí äàãóó ÕÄÕÂ/ÂÎÕ òàđõàõ, õèë äàìíóóëàí õçíèéã õóóëü áóñâàđ íàéìààèàõ ççýãäýëýñ óđüä÷èëàí ñýđãèéëýõ, îëíí íèéòýã ñóđòàë÷èáí òàíèóéàõ òãõíèè òóñëàëëòàáíû ò°ñ°ë

Улсын хил-Замын Үүд чиглэлийн 5,86км автозам

- Төслийн нэг хэсэг болох Улсын хилээс Замын үүд сум хүртлэх болон Замын үүд сум доторхи нийт 5,86км хатуу хучилттай зам барилгын ажлыг БНХАУ-ын буцалтгүй тусламжаар 2005 онд барьж ашиглалтанд оруулсан. Уг зам нь 18м-ийн зорчих хэсэгтэй, 4 эгнээгээр зорчдог, гэрэлтүүлэг бүхий, олон улсын жишигт нийцсэн зам бөгөөд барилгын ажлын гүйцэтгэгчээр БНХАУ-ын Бүх компани ажиллав. Энэхүү зам нь төслийн замын нэг хэсэг бөгөөд БНХАУ-ын хилээс эхлэх Монгол улс дахь Азийн авто замын сүлжээний нэг хэсэг юм.

Төсөл хэрэгжилтийн хугацаа

- Төслийн бэлтгэл ажлыг 2004 оноос эхэлсэн бөгөөд зам барилгын ажил 2005–2008 оныг дуустал хийгдэхээр төлөвлөж байна.

Төслийн хүрэх үр дүн

- АН-3 чиглэлд хатуу хучилттай авто замаар холбогдоно.
Төсөл хэрэгжсэнээр ОХУ, БНХАУ-ыг холбосон Монгол улс дахь Азийн авто замын АН-3 чиглэл хатуу хучилттай авто замаар холбогдох юм.
- Зам дагуух орон нутгийн хөгжилд үзүүлэх нөлөө
Төслийн үр дүнд төсөлд хамрагдах хоёр аймаг болон төслийн бүс нутагт худалдаа бизнесийн болон орлого нэмэгдүүлэх бусад үйл ажиллагааг өргөжүүлэх боломж бүрдэж зах зээлийн боломж нэмэгдэнэ. Төслийн бүс нутагт зорчих боломж дээшилж тээврийн зардал буурснаар хүнсний бараа орж ирэх урсгал нэмэгдэж хэрэглээний барааны үнэ буурна.
- Ажлын байр бий болгох
Төслийн явцад бий болох ажлын байруудад орон нутгийн иргэдийг өргөнөөр хамруулж тэдний орлогыг нэмэгдүүлэхэд анхаарна. Зам барилгын ажлын явцад мэргэжилтэй болон мэргэжилгүй Монгол ажилчдыг авч ажиллуулах бөгөөд ажлын дадлага туршлага эзэмшүүлэх сургалтуудыг зохион байгуулах юм. Зам ашиглалтанд орсны дараа түүгээр зорчигсдод үйлчлэх, замыг дагаж орж ирэх худалдаа, үйлдвэрлэлийн боломжийг ашиглах нөхцөл бүрдэнэ. Зам дагуух үйлчилгээний төвлөрсөн цэгүүд, ШТС, зочид буудал, ресторан, засварын цех, гар урлал болон бусад бүтээгдэхүүн худалдах дэлгүүр байгуулах замаар орлогоо нэмэгдүүлэх

Төслийн хүрэх үр дүн

- Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ

Төсөл хэрэгжих газар нутаг нь хагас хуурай уур амьсгалтай, сийрэг ургамалын бүрхэвчтэй хээр тал юм. Замыг элс, цасны нүүдлээс хамгаалах үүднээс замын трассын 15%-д шинээр мод тарина. Энэ нь цөлжилтийг бууруулахад зохих нөлөө үзүүлнэ. Төслийн зам баригдсанаар олон салаа зам гаргаж, хөрсийг эвдэх явдал зогсоно.

- Ойгоо хамгаалах арга хэмжээ

Хил хооронд авто тээвэр хийхэд ачаалал их байдийн улмаас цаг хугацаа алддаг зэрэг хүндрэлүүд байдаг. Төслийн бүрэлдэхүүнд хил дамнасан тээврийг хялбаршуулах хөтөлбөр багтаж байгаа бөгөөд энэ хүрээнд хил нэвтрэх ачаа, зорчигчдод хийх шалгалтын үр дүнг дээшлүүлэх талаар арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Төслийн хүрэх үр дүн

- ХДХВ/ДОХ, хүнийг хууль бусаар тээвэрлэх, наймаалах явдлаас сэргийлэх

Төсөл хэрэгжсэнээр тээвэрлэлтийн хэмжээ эрс нэмэгдэх ба үүнийг дагаж үүсч болзошгүй сөрөг үр дагавараас сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. Төслийн бүрэлдэхүүнд ХДХВ/ДОХ, хүнийг хууль бусаар тээвэрлэх, наймаалах явдлаас сэргийлэх хөтөлбөр багтаж байгаа бөгөөд олон нийтэд таниулах, сургалт явуулах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулна.

- Авто тээвэр хийх таатай нөхцөл бүрдэнэ.

Замын тэгш байдал сайжирч авто ослын тоо багасна. Тээврийн хэрэгслийн зорчих дундаж хурд зам баригдсанаар ойролцоогоор 2,2 дахин нэмэгдэж, аяллын дундаж хугацаа ойролцоогоор 2,28 дахин багасна.

АН-4 чиглэлийн зам

- Монгол улс дахь АН-4 чиглэлийн зам болох Ярантай – Ховд - Өлгий – Улаанбайшинт чиглэлийн 725 км замаас Ярант-Булган-Үенч чиглэлийн 65 км хатуу хучилттай зам 2005 оны 11 сард баригдаж дууссан.
- АХБ-ны Техник туслалцааны төслөөр баруун босоо тэнхлэгийн уг замын техник-эдийн засгийн судалгаа хийгдэхээр бэлтгэл хангагдаад байна.

АН-32 чиглэлийн зам

- Ховд – Улиастай – Цэцэрлэг – Хархорин – Лүн – Улаанбаатар - Өндөрхаан – Чойбалсан - Сүмбэр /Дорнод/ чиглэлийн 2520 км үргэлжлэх энэ зам нь хэвтээ тэнхлэгийн гол зам юм.
- Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа “Мянганы зам” төслийн хэвтээ тэнхлэгийн замтай ижил чиглэлтэй бөгөөд сүүлийн жилүүдэд зам барилгын ажил эрчимтэй явагдаж байна.
- АН-32 чиглэлийн нийт 2520 км –ээс одоогоор 403км буюу 16% нь хатуу хучилттай болоод байна. Үүнд урьд нь баригдсан байсан хатуу хучилттай замууд болон сүүлийн жилүүдэд шинээр баригдсан замууд орж байна.
- Хамгийн сүүлд Улаанбаатараас зүүн чиглэлд зорчдог замд Хэрлэнгийн Гүүр-Дуутын давааны чиглэлд 115 км хатуу хучилттай авто зам 2005 онд ашиглалтанд орсон.

Азийн авто замын сүлжээний ач холбогдол, үр өгөөж

- Монгол улс дахь Азийн авто замын сүлжээний дээрх гурван чиглэлийн замыг бүрэн хэмжээгээр барьж дууссанаар Ази Европын улс орнууд болон Монгол улс хөрш зэргэлдээ орнуудтай худалдаа харилцааг хөгжүүлэх хамгийн дөт авто тээврийн сүлжээ бий болно.
- ОХУ болон БНХАУ-ын хооронд транзит авто тээвэр хийгдэх боломжтой болно.
- Хөрш улсуудаас манай орон руу болон ОХУ, БНХАУ-ын хооронд авто тээвэр хийхэд хялбар болж, тээвэрлэлтийн хугацаа багасаж, авто тээврийн хэмжээ нэмэгдэн, бүс нутгийн болон Монгол улсын эдийн засагт чухал нөлөө үзүүлнэ.
- Монгол улс далайн боомтод авто замаар хүрэх боломж нээгдэнэ.

Азийн авто замын сүлжээний ач холбогдол, үр өгөөж

- Олон улсын транзит тээвэр манай улсаар дамжин өнгөрөхтэй холбогдуулан замын дагуух 100 км тутамд үйлчилгээний иж бүрэн цогцолбор байгуулагдаж орон нутагт ажлын байр бий болж амжиргааны төвшин мэдэгдэхүйц хэмжээгээр нэмэгдэнэ.
- Монгол орны баруун, зүүн бүсийн алслагдмал аймгийн төвүүд хоорондоо болон нийслэлтэй хатуу хучилттай замаар холбогдсоноор зах зээлд ойртож, нийгмийн халамж үйлчилгээ сайжирна.
- Транзитаар зорчих тээврийн хэрэгслүүдээс хураамж авсанаар замын засвар үйлчилгээнд зарцуулах хөрөнгө нэмэгдэнэ.
- Бүс нутгийн дэд бүтэц сайжирснаар Монгол улсад ирэх гадаадын жуулчдын тоо өсөж аялал жуулчлалын салбар хөгжих нөхцөл бүрдэнэ.
- Нийслэл хот руу хөдөө орон нутгаас олноор шилжин ирж хэт төвлөрөл үүсэх явдал багасна.



**АНХААРАЛ ТАВЬСАНД
БАЯРЛАЛАА !**